



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/128

Биндэр сум

**Бруцеллёз өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалтууд, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2024 оны А/276 дугаар тушаал, Хэнтий аймгийн Засаг даргын 2024 оны 09 сарын 13-ны өдрийн А/472 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээний бүх тугал, хурга, ишгийг зааврын дагуу вакцинжуулалтанд хамруулах ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 15 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.
2. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг тогтоосон хугацаанд шуурхай, чанартай хийж гүйцэтгэхийг гэрээт мал эмнэлгийн нэгжүүдийн захирал, малын эмч нарт үүрэг болгосугай.
3. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг малчид, мал бүхий иргэдэд зарлан мэдээлж, зохих бэлтгэлийг хангуулан хамтран зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт, товлосон хугацаанд тарилгад хамрагдах малаа бэлэн байлгаж бүрэн хамруулах, тарилга хийх хашаа хороо бэлтгэн аюулгүй байдлыг ханган ажиллахыг малчид, мал бүхий иргэдэд даалгасугай.
4. Тарилгын ажилд хяналт тавих, холбогдох мэдээ тайланг цаг хугацаанд нь хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Батдаваад, захирамжийн хэрэгжилтийг хангуулж, явцын болон гүйцэтгэлийн тайланд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч С.Ганбат нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

Data (D:) /A4 zahiramj/

232401321